

**“ТАСРАЛТГҮЙ ТЭЖЭЭЛИЙН ТӨХӨӨРӨМЖ /UPS-ЫН СЭЛБЭГ/” НИЙЛҮҮЛЭХ
НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН
БАРИМТ БИЧИГ**

**Тендер шалгаруулалт
гэрээний нэр:** *“Тасралгүй тэжээлийн төхөөрөмж /UPS-ын сэлбэг”
нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер*

Тендерийн дугаар: ИНЕГ/УЗ/ХББ/Б-56/19

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2019.05.06

Иргэний нисэхийн ерөнхий газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Тасралгүй тэжээлийн төхөөрөмж /UPS-ын сэлбэг” нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт цахим үнийн санал ирүүлэхийг урьж байна.

1. Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.
2. Үнийн саналыг **2019 оны 06 дугаар сарын 07–ны 10.00 цагаас** өмнө **Иргэний нисэхийн ерөнхий газрын ХААТасаг 108 тоот** хаягаар болон Төрийн худалдан ажиллагааны цахим систем www.tender.gov.mn цахим системээр ирүүлнэ.
3. Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 06 дугаар сарын 07** -ны өдрийн **10.30 -цагт** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар тодруулж болно._

**Улаанбаатар хот, Буянт-Ухаа,
Иргэний нисэхийн ерөнхий газар
Худалдан авах ажиллагааны тасаг. 108 тоот.
утас : 282037**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. **Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
 - 6.2. Тендерийн хүчинтэй байх хугацаа нь хуульд заасан хүчинтэй байх хугацаанаас богино байх тохиолдолд захиалагч түүнийг үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж татгалзана.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
 - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
 - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. **Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
 - 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 1 жилийн /2018 он/ санхүүгийн тайлан ирүүлэх. 2. Сүүлийн 1 жилийн /2018/ ижил төстэй ажлын туршлагын мэдээлэл ирүүлэх. /Ижил төстэй тоног төхөөрөмж нийлүүлж байсан гэрээний хуулбар гэрээ дүгнэсэн актын хамт ирүүлэх/ 3. Сүүлийн 1 жилд санхүүгийн тайлангаар ашигтай ажилласан байх шаардлагатай. 4. Сүүлийн 1 жилийн /2018 оны борлуулалтын орлого нь төсөвт өртгийн 100 хувиас багагүй байна./ 5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт ирүүлэх. 6. Нийгмийн даатгалын хэлтсийн тодорхойлолт ирүүлэх. 7. Татварын албаны тодорхойлолт ирүүлэх. /Татварын өр төлбөргүй болохыг нотлох цахим тодорхойлолт ирүүлэх/ 8. Хуудас бүрийг дугаарлах: Тендерт оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээд хуудас бүрийг арилдаггүй бэхээр дугаарлан гарын үсэг зурж баталгаажуулсан байх шаардлагатай. 9. Бараа нийлүүлэх хуваарийг маягтын дагуу ирүүлэх. /Хуанлийн 60 хоногт нийлүүлэх шаардлагатай. Ирүүлээгүй тохиолдолд үндсэн шаардлага хангахгүй гэж үзнэ./ 10. Батлагдсан техникийн шаардлагыг хангасан байна. Техникийн шаардлагыг ирүүлэхдээ техникийн шаардлагын заалт бүрийг хангаж буй тухай нийцлийн хүснэгт хийн ирүүлэх шаардлагатай. 11. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ. 12. Үйлдвэрлэгчийн чанарын баримт бичиг эсвэл техникийн баримт бичгийг дагалдуулж ирүүлнэ. 13. Үйлдвэрлэгчийн эсхүл албан ёсны эрхтэй борлуулагчаас олгосон нийлүүлэх эрхийн зөвшөөрөл ирүүлнэ.
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: <i>Тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn цахим хуудсаар цахимаар ирүүлэх.</i></p> <p>Огноо: 2019 оны 06 дугаар сарын 07 -ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>Хан-Уул дүүрэг 10-р хороо, Иргэний нисэхийн ерөнхий газар. Худалдан авах ажиллагааны тасаг.</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>1 давхар 108 тоот. /Цахим өрөө/</i></p> <p>Огноо: 2019 оны 06 дугаар сарын 07 –ны өдөр</p>

	Цаг: 10 цаг 30 минут
ТООЗ 6.2	“Тасралгүй тэжээлийн төхөөрөмж /UPS-ын сэлбэг” нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт. ИНЕГ/УЗ/ХББ/Б-56/19

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэ техникийн тодорхойлолтод 20кВА чадал бүхий 3 фазын тасралтгүй тэжээлийн төхөөрөмж /UPS/-ийг нийлүүлэх техникийн үзүүлэлтийг тусгасан болно.

2. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Нийлүүлэгч нь техникийн тодорхойлолтод нийцсэн тоног төхөөрөмжийг нийлүүлнэ.

- Баталгаат хугацаа: Захиалагч тал ажил хүлээн авах актад гарын үсэг зурж, хүлээн авснаас хойш 12 сар.
- Нийлүүлэгдэх тоног төхөөрөмжүүд нь шинэ байх ба батарейнууд нь заавал 2019 онд үйлдвэрлэгдсэн байна.
- Техникийн бичиг баримт, зааврууд нь англи хэл дээр байна.

3. ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтүүд доорх шаардлагыг хангасан эсхүл **Rellio ups-MST-MCT 20 kVA UPS**-тэй дүйцэхүйц тоног төхөөрөмж байна.

№	Техникийн үзүүлэлт	Тавигдах шаардлага	
3.1	Техникийн үндсэн шаардлага	VFI Type	Online
		Оролт	Үндсэн ба нөөц гэсэн 2 оролттой байна.
			<ul style="list-style-type: none"> • Фаз дутуу, фазын дараалал буруу, хүчдэл, давтамжийн утга заасан хязгаараас давсан зэрэг хэвийн бус оролтын үед батарей горимд ордог байна.
		Хяналт, удирдлага	<ul style="list-style-type: none"> • LED/LCDдэлгэц дээр UPS-ийн төлөв байдал, параметрууд /оролт гаралтын хүчдэл, гүйдэл, давтамж, батарейний үзүүлэлтүүд/, хадгалагдсан архив зэргийг үзүүлдэг байна. • Хэвийн бус горимын үед гэрлэн болон дуут дохиолол өгдөг байх • Алсын хяналтад холбогдох LAN интерфейс, Dry contact-тай байх
		Ажиллах орчны температур	0 ÷ 40°C (32 - 104°F)
Хамгаалалтууд	Богино залгааны хамгаалалт:	<ul style="list-style-type: none"> • RECTIFIER • RESERVE • BYPASS NFB 	
		Хэт хүчдэлийн EMC FILTER	

3.2	Үндсэн оролтын параметр	Оролтын хүчдэл	380/400/415VAC 3 Phase 4 Wire
		Оролтын хүчдэлийн хязгаар /Ph-Ph/	310 – 490VAC
		Давтамж	50Hz ±5%
		Current distortion	THDI ≤ 3%
3.3	Нөөц оролтын параметр	Оролтын хүчдэл	380/400/415VAC 3 Phase 4 Wire
		Давтамж	50Hz + ±5%
		Current distortion	THDI ≤ 3%
3.4	Инвертер	DC оролтын хүчдэлийн хязгаар	285 – 420VDC
		Wave form	Sine wave
		Гаралтын хүчдэл	380/400/415 VAC 3 Phase 4 Wire
		Гаралтын давтамж	50 ±0.1 Hz
		Хэт ачаалал	<ul style="list-style-type: none"> • <110%: CONTINUOUS • 110 – 125%: 15 min • 125 – 150%: 10min • > 150% 60 sec Эдгээр нөхцөлөөр Bypass горимд шилждэг байх
3.5	Static switch	Хүчдэлийн хязгаар	173–277 VAC (Ph-N)
		Шилжилт	<ul style="list-style-type: none"> • RESERVE -> INVERTER: 0ms • INVERTER ->RESERVE: 0ms
		Isolation with output	Yes
3.6	Батарей.	Төрөл	SEAL LEAD ACID / NiCd
		Хүчдэлийн хязгаар	295 – 410VDC / 285-415VDC
		Battery low voltage	320VDC / 305VDC
		Battery low stop voltage	295VDC / 285VDC
		BOOST CHARGE	402VDC / 415VDC
		FLOAT CHARGE	390VDC / 410VDC
		Тоо	30ш
		Гүйдэл	80÷100 A/ц
		Бусад шаардлага	<ul style="list-style-type: none"> • Батарейнууд нь тусдаа батарей банкттай байна. • Батарейнуудад хэмжилт болон үйлчилгээ хийх боломжтой байна.

4. НИЙЛҮҮЛЭХ ТОО ХЭМЖЭЭ

№	Тоног төхөөрөмжийн нэр	Хэмжих нэгж	Нийлүүлэх тоо	Техникийн үзүүлэлт
1	Үл тасалдал бүхий тэжээлийн төхөөрөмж /UPS/	Иж бүрдэл	1	3-т заагдсан техникийн үзүүлэлтийг бүрэн хангасан байна

2	Battery cabinet		1	3-т заагдсан техникийн үзүүлэлтийг бүрэн хангасан байна
3	Төхөөрөмжийн тохиргоог хийх notebook		1	Зориулалтын зөөврийн байх. Processor-Intel(R) Core i7 CPU 3.40Hz 3.40Hz RAM-8.00GB
4	Configuration хийх software, програмууд, холболтын USB кабел, гарын авлага, CD		1	Техникийн тодорхойлолтод нийцсэн байх

5. ХҮЛЭЭН АВАХ

ИНЕГ-ын даргын тушаалаар томилогдсон ажил хүлээн авах комисс нь техникийн тодорхойлолтын дагуу техникийн үзүүлэлт болон иж бүрдлийг шалгаж, туршиж, хүлээн авах актыг үйлдсэнээр барааг хүлээн авсанд тооцно.

Ачааг хүргэх цэг. Иргэний нисэхийн ерөнхий газрын харъяа Холбоо, навигаци, ажиглалтын алба байна.

Тав. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа/ DDP нөхцөл/		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
UPS тоног төхөөрөмж	Техникийн тодорхойлолт тод заасны дагуу	Техникийн тодорхойлолтод заасны дагуу	Техникийн тодорхойлолтод заасны дагуу	ИНЕГ	Хуанлийн 60 хоног	Хуанлийн 60 хоног	

Зургаа. ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга Л.Бямбасүрэн танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Тендер хүчинтэй байх хугацаа [хүчинтэй хугацааг заах] хоног байна.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Долоо. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|---|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат хугацаа 2 жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Найм. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
 - 1.1. Барааны техникийн шаардлага тоо хэмжээг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор бараа, материал дээр хяналт хийсний дараа захиалагч барааг хүлээн авсанд тооцно.

 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
 - 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
 - 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
-
3. Баталгаат засвар (ГЕН-5)
 - 5.1. Чанарын шаардлага бүрэн хангасан байна.
-
4. Төлбөр (ГЕН – 7)
 - 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
 1. Урьдчилгаа төлбөр: Урьдчилгаа төлбөрийг банкинд гаргасан урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн 40 хүртэл хувиар олгоно.
 2. Бараа, материалыг нийлүүлсний дараа хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн акт болон нэхэмжлэхийг үндэслэн 55% төлбөрийг төлнө.
 3. Чанарын баталгаа: Гэрээний үнийн 5 %-тай тэнцэх дүнг барааг хүлээн авч, гэрээг дүгнэсэн өдрөөс хойш 1 жил байна.
-
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)
 - 9.1 Алданги оногдуулах хувь хоногт: **0,5%**
Алдангийн нийт дүн: **50%**
-
6. Маргааныг шийдвэрлэх (ГЕН - 11)
 - 11.1 Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Ес. ГЭРЭЭНИЙ МАЯГТ¹

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг²;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

¹ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

² Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]